



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/358

Хэрлэн сум

Аймгийн нөөцийн агуулахын засварын ажилд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалт нийтлэг журамын 2.1.1 дэх хэсэг, аймгийн Онцгой комиссын 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн өмчийн газрын эзэмшлийн Аймгийн нөөцийн агуулахын хашаа, саравч 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн байгалийн аюулт үзэгдэлийн улмаас, эвдэрсэн тул засварын ажилд зориулан 3,430,000 ( гурван сая дөрвөн зуун гучин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Засварын ажилд шаардагдах тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн хохиролыг бууруулах, үр дагаварийг арилгах зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 06 дугаар сарын 22-ны  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Засварын зардлын тооцоо

Д/Д	Материалын нэр	Тоо ширхэг	Үнэ	Нийт үнэ
1	Блок	100ш	2500	250,000
2	Цемент	10 шуудай	25,000	250,000
3	Хайрга	1 машин	500,000	500,000
4	Цонхны шил	1 цонх	80,000	80,000
5	Саравчны дээвэр	-	-	300,000
6	Өрлөгийн хөлс	-	-	1,800,000
7	Тээврийн зардал	-	-	250,000
Нийт				3,430,000